



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 7/25

Ховд

Г
Журам батлаж, орон тооны бус техникийн
мэргэжлийн зөвлөл байгуулх тухай

“Барилгын тухай “ Монгол улсын хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт, “Газрын тухай” хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь заалт, Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Техникийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг 1 дүгээр хавсралтаар, орон тооны бус техникийн мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэн, гарсан шийдвэрийг тухай бүрт танилцуулж ажиллахыг зөвлөлийн дарга /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/221 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/25 Ch

02 00122

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 14-ний өдрийн
A/25 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ОРОН ТООНЫ БУС ТЕХНИКИЙН
МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Ховд аймгийн нутаг дэвсгэрт шинээр барих, өргөтгөх, шинэчлэх “Барилгын тухай хууль” –ийн 4.1.1-т заасан инженерийн хийцтэй бүх төрлийн байгууламж (цаашид “барилга байгууламж гэх)-ийн барилгын техникийн нөхцөл олгоход мөрдлөг болгоно.

1.2 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.2.1.“барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг;

1.2.2.“барилга байгууламжийг засварлах, тоноглох” гэж ашиглалтын хэвийн нөхцлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг;

1.2.3.“барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх” гэж барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэлт хийх үйл ажиллагааг;

1.2.4.“барилга байгууламжийн техникийн нөхцөл” гэж барилга байгууламжийг дулаан, уур, хий, цэвэр, бохир ус, цахилгаан, харилцаа холбоо, дохиолол зэрэг эх үүсвэрт холбох эрх бүхий хуулийн этгээдээс гаргах шийдвэрийг;

1.2.5.“техникийн нөхцлийн нэгдсэн хуудас” гэж тухайн барилга байгууламжийн байршлын схем бүхий техникийн нөхцөл олгох эсэх талаар гаргасан техникийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн гарын үсэг бүхий нэгдсэн хуудсыг;

Хоёр: Техникийн нөхцлийн өргөдөл хүлээж авах, шийдвэрлэх

2.1 Техникийн нөхцөл хүсэгч нь Техникийн мэргэжлийн зөвлөлд хүсэлтээ гаргана.
/Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар/

2.2 Зөвлөлийн нарийн бичгийн дарга хүсэлтийг хүлээн авч хангагч байгууллагуудад хүргүүлнэ. /1 хоногт багтаан/

2.3 Инженерийн хангамжийн байгууллага хариуг ажлын 5 хоногт багтаан өгч Зөвлөлийн нарийн бичгийн дарга Техникийн мэргэжлийн зөвлөлийн хуралд оруулж эцсийн шийдвэр гаргуулна. /14 хоногт 1 удаа Лхагва гарагт/

Тухайн байгууллагын ерөнхий инженер шалтгаантай үед орлон ажиллах хүнийг томилж албажуулан зөвлөлд ирүүлнэ.

2.4 Техникийн нөхцөл авах хүсэлтэд дараахь баримт бичгийг хавсаргана.

- 2.4.1.эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл;
- 2.4.2.барилга барих газрын нэгж талбарын кадастрын зураг, түүний нөхцөл, байдлыг харуулсан гэрэл зураг;
- 2.4.3.хүсэлт гаргасан этгээдийн иргэний үнэмлэх, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
- 2.4.4.өргөдлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр хүргүүлэх тохиолдолд итгэмжлэл;
- 2.4.5.барилга архитектурын загвар зураг;
- 2.4.6.техникийн нөхцөл олгоход шаардагдах барилга байгууламжийн хүчин чадал, инженерийн хангамжийн хэрэгцээг тодорхойлсон мэдээлэл.

2.5.Инженерийн хангамжийн байгууллага техникийн нөхцөл олгохоос татгалзсан нь хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангахад саад болохгүй.

2.6.Хүсэлт гаргасан этгээд инженерийн хангамжийн хэрэгцээг өөрийн эх үүсвэрээр хангах зураг төсөл боловсруулан баталгаажуулсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрөл олгож болно.

2.7 Техникийн зөвлөлөөс дэмжигдсэн шийдвэр гараагүй барилга байгууламжид ганцаарчилж техникийн нөхцөл олгохыг хориглоно.

Гүйцэтгэгч өөрийн техникийн нөхцлийн дагуу хийсэн эхний шугам сүлжээнээс дахин нэмж холболт хийхээр бол хангагч болон зөвлөлөөс зөвшөөрөл авна.

2.8 Техникийн зөвлөлөөс гарах шийдвэр нь хурлын тэмдэглэл болон техникийн нөхцлийн нэгдсэн хуудсаар баталгаажих ба дэмжигдсэн тохиолдолд техникийн нөхцлийн тойрох хуудсыг техникийн мэргэжлийн зөвлөлийн гишүүд зөвшөөрснөөр аймгийн Ерөнхий архитектор баталгаажуулна.

2.9 Техникийн зөвлөл нь гишүүдийн 2/3-оос доошгүй ирц бүрдсэнээр ажиллах бөгөөд мэргэжлийн чиглэлээрээ дараахь үүргийг гүйцэтгэж, саналаа танилцуулж ажиллана.

2.9.1 Тухайн барилга байгууламж нь ард иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг хангасан байх, байршил нь ерөнхий төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх, холбогдох хууль, дүрэм журам, норм стандартын шаардлага хангаж байх, тухайн инженерийн хангамжийн эх үүсвэрийн найдвартай байдал, хангах нөөц боломжийг судалсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

2.9.2 Тухайн зөвлөлийн гишүүн нь техникийн нөхцөл олгох боломжгүй бол тэрхүү үндэслэл шалтгааныг тодорхой тайлбарласан байна.

2.9.3 Техникийн нөхцлийн тойрох хуудас баталгаажсанаар хангагч байгууллагууд тус тусын техникийн нөхцлийг хавсралтаар гаргаж хүргүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 дүгээр сарын 14-ний өдрийн
A/25 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

Зөвлөлийн дарга: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд
Б.Гантөмөр - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Баярсүх - Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга

П.Эрдэнэчулуун - Мэргэжлийн хяналтын газрын
дарга

Г.Ганжаргал - Онцгой байдлын газрын Галын түймрийн
улсын хяналтын байцаагч

Н.Амаржаргал - “Шим–Ус” орон нутгийн өмчит аж
ахуйн тооцоот үйлдвэрийн
газрын ерөнхий инженер

Н.Мөнхцэцэг - Дулааны “Бадамлах дөл” ХХК-ний
ерөнхий инженер

С.Чинзориг- “Ховд дулааны станц” төрийн
өмчит хувьцаат компаний ерөнхий инженер

У.Пүрэвдорж - “Ховд цахилгаан түгээх сүлжээ”
ХХК-ний ерөнхий инженер

Д.Алтанхуяг - Мэдээлэл холбооны сүлжээ” төрийн
өмчит хувьцаат компаний ерөнхий
инженер

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн ерөнхий архитектор

Нарийн бичгийн
дарга

Д.Тогтохбаяр - Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын БХБХ-ийн дарга

-оOo-